



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 35

Есөнбулаг сум

"Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах
бодлогыг хэрэгжүүлэх" дэд хөтөлбөр
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "Ж" заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх" дэд хөтөлбөрийг нэгдүгээр, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх" дэд хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусган батлуулж, биелэлтийн явц, үр дүнг жил бүрийн эцэст аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны
04 дүгээр сарын 22-ны өдрийн 35 дугаар
тогтоолын 1-р хавсралт



ТӨРӨӨС ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ДЭД ХӨТӨЛБӨР

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аймгийн эрүүл мэндийн салбарын 2010-2015 оны хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүллээ.

Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөөний бодлогын баримт бичгийн хэрэгжих хугацаа дууссан, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого батлагдсантай холбоотойгоор аймгийн дараагийн 10 жилийн хөгжлийн баримт бичиг болох дэд хөтөлбөрийг боловсруулах хэрэгцээ шаардлага бий боллоо.

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэдний эрэлт хэрэгцээнд тулгуурлан зохион байгуулж, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлж, эрүүл мэндийн салбарт зохистой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлснээр тусламж, үйлчилгээний чанар хүртээмж сайжрах болно.

Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд хоол боловсруулах эрхтний, амьсгалын тогтолцооны, цусны эргэлтийн тогтолцооны, шээс бэлгэсийн тогтолцооны, нүд ба түүний дайврын өвчнүүд, нас баралтын тэргүүлэх шалтгаанд цусны эргэлтийн тогтолцооны өвчин, хавдар, хоол шингээх эрхтний өвчин, амьсгалын тогтолцооны өвчнүүд орж байна. Хүн амын дунд халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх талаар мэдлэг, хандлага, дадал хангалтгүй байгаа бөгөөд ус, хөрсний бохирдол ихсэх, ахуйн болон зам тээврийн осол, гэмтэл нэмэгдэх эрсдэл өссөөр байна.

Монгол Улсын Засгийн газар, Эрүүл мэндийн Яамны хөрөнгө оруулалт, олон улсын байгууллагуудын төсөл, хөтөлбөр, хандив, тусламжаар эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалт нэмэгдэж, тоног төхөөрөмж, технологийг шинэчлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг хэрэгжүүлэхэд ахиц гарч байна.

Хүн амын эрүүл мэндийн тусламжийн эрэлт хэрэгцээ, өвчлөл, нас баралтын чиг хандлага, нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалд нийцүүлэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалтыг оновчтой болгох, хүртээмж чанарыг дээшлүүлэх, салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх, технологи мэдээллийг сайжруулахад төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд олон нийтийн оролцоог сайжруулах шаардлагатай байна.

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх Говь-Алтай аймгийн дэд хөтөлбөрийг “Хэнийг ч орхигдуулахгүй байх зарчим”-д тулгуурлан боловсрууллаа.

ХОЁР. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗАРЧИМ, ЗОРИЛТ

2.1. Хөтөлбөрийн зорилго

Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэдний эрэлт, хэрэгцээнд тулгуурлан аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэх, эрүүл мэндийн салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан Монгол хүний дундаж наслалтыг уртасгахад оршино.

2.2. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

2.2.1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн бодлоготой уялдсан байх;

2.2.2. Иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх;

2.2.3. Үйлчлүүлэгчийн эрхийг дээдэлсэн, тэдний эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байх;

2.2.4. Нотолгоонд суурилсан, орчин үеийн оношлогоо, эмчилгээний техник технологийн дэвшлийг нэвтрүүлсэн байх;

2.2.5. Хөтөлбөрийн хэрэгжилт, ил тод байдлыг хангасан байх;

2.2.6. Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог хангасан байх.

2.3. Дэд хөтөлбөрийн зорилтууд

Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлнэ:

2.3.1. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр:

2.3.1.1. Зонхилон тохиолдох өвчний эрт илрүүлгийн үзлэгийг чанартай хийж, халдварт бус өвчин тэдгээрийн эрсдэлт хүчин зүйл, тархалтыг тогтоож, сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олны оролцоонд тулгуурлан бууруулах;

2.3.1.2. Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл зан үйл, аж төрөх хэв маягийг төлөвшүүлэх;

2.3.1.3. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;

2.3.1.4. Сүрьеэ, БЗДХ/ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх, эрт илрүүлж, төгс эмчлэх замаар халдварын тархалтыг бууруулах,

2.3.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр:

2.3.2.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг газар зүйн байршил, хүн амзүйн бүтэц, өвчлөл, ядуурлын түвшин, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт, хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулах;

2.3.3. Хүний нөөцийн чиглэлээр:

2.3.3.1. Нэн шаардлагатай мэргэшлийн чиглэлээр эмнэлгийн мэргэжилтэн

бэлтгэх, орон нутгийг эмнэлгийн мэргэжилтнээр хангах, тогтвор суурьшилтай ажиллуулахад орон нутгийн дэмжлэг оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах;

2.3.3.2. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг өндөр хөгжилтэй оронд туршлага

судлуулах, мэргэшүүлэн бэлтгэх;

2.3.4. Эрүүл мэндийн санхүүжилтийн чиглэлээр:

2.3.4.1. Салбарын дэд бүтэц, хөрөнгө оруулалтыг сайжруулах;

2.3.4.2. Аймгийн эрүүл мэндийн салбарын нийт зардалд өрх, сумын эрүүл

мэндийн төвийн буюу анхан шатны тусламж үйлчилгээний зардлын эзлэх хувийг нэмэгдүүлэх;

2.3.5. Эрүүл мэндийн технологийн чиглэлээр:

2.3.5.1. Эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, оношлох, эмчлэх, нөхөн сэргээх болон эрүүл мэндийн мэдээллийн өртөг зардал хямд, хүртээмжтэй технологийг нэвтрүүлэх замаар хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах;

2.3.6. Эм зүйн тусламж, үйлчилгээний чиглэлээр:

2.3.6.1. Сумдын эргэлтийн эмийн сангийн бүтэц, зохион байгуулалтыг шийдвэрлэн, тусгай зөвшөөрөлтэй болгон, иргэдэд чанартай үйлчилгээг хүргэх;

2.3.7. Мэдээллийн технологийн чиглэлээр:

2.3.7.1. Сумын эрүүл мэндийн төвтэй цахимаар хурал хийж, мэдээ, мэдээллийг шуурхай солилцох боломжийг ханган ажиллах;

2.3.7.2. Телемедицин, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологийг ашиглан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах үйл ажиллагааг өргөжүүлэх.

2.3.8 Эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

2.3.8.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний ил тод байдлыг хангах, шийдвэр гаргахад иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлж, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх.

2.4 Хөтөлбөрт аймгийн төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн бүхий л байгууллага хамрагдана.

ГУРАВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ, ХЭРЭГЖИХ ХУГАЦАА

3.1 Дэд хөтөлбөрийн хэрэгжилт нь үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тодорхойлогдох бөгөөд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлнэ.

3.2 Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

3.2.1 Улсын болон орон нутгийн төсөв;

3.2.2 Олон улсын байгууллага, гадаад орны төсөл, хөтөлбөрийн хөрөнгө;

3.2.3 Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

3.2.4 Бусад эх үүсвэр.

3.3 Дэд хөтөлбөрийг 2017-2021 онд хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

4.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэж, улмаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнана.

4.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хяналт үнэлгээг хийнэ.

ТАВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд Засаг даргын Тамгын газар, Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс удирдлага, төлөвлөлтөөр хангаж ажиллана.


5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт, холбогдох журам боловсруулах, хөрөнгийг гаргах асуудлыг аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

5.3. Эрүүл мэндийн газар нь төрийн болон төрийн бус байгууллагыг мэргэжлийн арга зүйгээр хангаж, манлайлан оролцоно.

5.4. Хөтөлбөрийг орон нутгийн хэмжээнд иргэд, төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүд хэрэгжүүлэн ажиллана.

----oOo----

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 04
 дүгээр сарын 25-ны өдрийн 35 дугаар
 тогтоолын 2.1-р хавсралт



**ТӨРӨӨС ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮДЭХ
 АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
 /2018-2021 ОН/**

Дугаар	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа	Санхүүжилт /сая төгрөгөөр/
1.	Нийгмийн эрүүл мэнд						
1.1 Зонхилон тохиолдох өвчний эрт илрүүлгийн үзлэгийг чанартай хийж, халдварт бус өвчин тэдгээрийн эрсдэлт хүчин зүйл, тархалтыг тогтоож, сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олны оролцоонд тулгуурлан бууруулна.							
1.1.1	“Элэг бүтэн Алтай” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Элэгний хавдраас шалтгаант нас баралтын хувь буурна	Нийт хүн амын 70-с доошгүй хувийг хамруулна.	Эрүүл мэндийн газар	ЭМБ-ууд	2017-2020	ОНТ
1.1.2	“Халдварт бус өвчнөөс сэргийлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлнэ.	Төлөвлөгөөний хэрэгжилт 90-ээс доошгүй хувь	Эрүүл мэндийн газар	ЭМБ-ууд	2017-2020	ОНТ
1.2 Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл зан үйл, аж төрөх хэв маягийг төлөвшүүлэх							
1.2.1	Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, өрх, иргэний тоог нэмэгдүүлнэ	Иргэдийн эрүүл зан үйл төлөвшиж өвчлөл, нас баралт буурна	Жил бүр 20-оос доошгүй нэгж	Эрүүл мэндийн газар	Сумдын ЗДТГ, СЭМТ, ӨЭМТ	2017-2020	4.0-ОНТ
1.3 Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах							
1.3.1	“Нөхөн үржихүйн эрүүл мэнд” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.	Охидын жирэмслэлтийг бууруулна. Эхийн эндэгдэлгүй ажиллана	Төлөвлөгөөний хэрэгжилт 90-ээс доошгүй хувь	Эрүүл мэндийн газар	ЭМБ-ууд	2017-2020	ОНТ
1.4 Сүрьеэ, БЗДХ, ХДХВ-ын халдвараас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлж төгс эмчлэх замаар халдварын тархалтыг бууруулах							

1.4.1	Бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх үзлэгийг жил бүр 2-оос доошгүй удаа зохион байгуулж, эмчлэх, хянах ажлын үр дүнг тооцож ажиллана.	Бэлгийн замаар дамжих халдварын тархалтыг бууруулна.	Илрүүлэлтийг өмнөх оноос нэмэгдүүлсэн байна.	Эрүүл мэндийн газар	ЭМБ-ууд	2017-2020	12.5-ОНТ
1.4.2	Хүн амын дунд сүрьеэгийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэлт, төгс эмчилгээний чанарт хяналт тавьж тархалтыг хязгаарлана.	Сүрьеэгийн халдварын тархалтыг бууруулна.	Эдгэрэлтийг 85-аас доошгүй хувьд хүргэнэ.	Эрүүл мэндийн газар	ЭМБ-ууд	2017-2020	12.5-ОНТ
2.	Эмнэлгийн тусламж үйлчилгээ						
2.1 Эмнэлгийн тусламж, үйлчилгээг газар зүйн байршил, хүн амзүйн бүтэц, өвчлөл, ядуурлын түвшин, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт, хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулах							
2.1.1	Сумдын хүн амд явуулын амбулаториор үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.	Хэнийг ч орхигдуулахгүй тусламж үйлчилгээг хүргэнэ	Жил бүр бүх сумд хүрч, тухайн сумын хүн амын 30-аас доошгүй хувь	Эрүүл мэндийн газар	ЭМБ-ууд	2017-2021	ОНТ
2.1.2	Аймгийн Нэгдсэн эмнэлгийг түшиглэн Яаралтай тусламжийн төв \нэгж\ байгуулж ажиллана	Хоног болоогүй нас баралтыг бууруулна	төв \нэгж\ байгуулагдсан байна	ЭМГ	ИТХ, АЗДТГ,	2018-2019	Төсөл хөтөлбөр ОНТ
3.	Хүний нөөц						

3.1 Нэн шаардлагатай мэргэшлийн чиглэлээр эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх, орон нутгийг эмнэлгийн мэргэжилтнээр хангах, тогтвор суурьшилтай ажиллуулахад орон нутгийн дэмжлэг оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах							
3.1.1	Клиникийн төв эмнэлгүүдтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан, гэрээний дагуу эмч мэргэжилтнүүдийг сэлгэн ажиллуулах.	Эмнэлгийн тусламжийн чанар сайжирна.	Жилд 2-с доошгүй эмнэлгийн мэргэжилтэн	Эрүүл мэндийн газар	ЭМГ, НЭ	2018-2021	5,3-ОНТ
3.1.2	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд ажил мэргэжлийн уралдааныг уламжлал болгон явуулах.	Эмнэлгийн тусламжийн чанар сайжирна.	Жил бүр зохион байгуулаж хэвшсэн байна.	ЗДТГ, ЭМГ	СЗДТГ, ЭМБ-ууд	2017-2021	УТ
3.2 Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг өндөр хөгжилтэй оронд туршлага судлуулах, мэргэшүүлэн бэлтгэх							
3.2.1	Эмч мэргэжилтнүүдийг гадаад улсад мэргэжил дээшлүүлэх урт, богино хугацааны сургалтанд хамруулж чадавхижуулах	Эмнэлгийн тусламжийн чанар сайжирна.	Жилд 6-с доошгүй эмнэлгийн мэргэжилтэн	Эрүүл мэндийн газар	АИТХ, ЗДТГ	2017-2021	10,0-ОНТ
3.2.2	Эрүүл мэндийн ажилтнуудыг гадаад оронд туршлага судлуулах, танилцах аялалд хамруулна.	Эмнэлгийн тусламжийн чанар сайжирна.	Жилд 4-с доошгүй эрүүл мэндийн ажилтан	Эрүүл мэндийн газар	АИТХ, ЗДТГ	2017-2021	5,0-ОНТ
4.	Эрүүл мэндийн санхүүжилт						
4.1 Салбарын дэд бүтэц, хөрөнгө оруулалтыг сайжруулах							
4.1.1	Марал-Алтай өрхийн эрүүл мэндийн төвийг шинэ барилгатай болгоно.	Үйлчлүүлэгчид ээлтэй орчин бүрдэнэ	1	Эрүүл мэндийн газар	АЗДТГ, СЗДТГ	2017-2021	200,0 -ОНТ

4.1.2	Нэгдсэн эмнэлгийг нэн шаардлагатай байгаа нярайн шарлагын аппарат, яаралтай тусламжийн тоног төхөөрөмжөөр хангана.	Хүүхдийн тусламж үйлчилгээний чанар сайжирна.	4-өөс доошгүй нэр төрөл	Эрүүл мэндийн газар	АЗДТГ НЭ	2017-2020	32,0-ОНТ
4.1.3	Нэгдсэн эмнэлгийн тасгуудыг ханын хүчилтөрөгчийн системд холбоно.	Тусламж үйлчилгээний чанар сайжирна.	7 тасаг холбогдоно	Эрүүл мэндийн газар	АЗДТГ, НЭ	2017	80,0-ОНТ
4.1.4	Нэгдсэн эмнэлгийн хог хаягдлын барилгад цэвэр ус, дулааны асуудлыг шийдвэрлэнэ.	Эмнэлгээс шалтгаалах халдвар буурна.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Эрүүл мэндийн газар	АЗДТГ НЭ	2017	34,7-ОНТ
4.1.5	Багийн эмч нарын унааг /мотоцикль/ ээлж дараатайгаар шинэчилнэ.	Багийн эмчийн эргэлт сайжирна	36	Эрүүл мэндийн газар	АЗДТГ, СЗДТГ	2017-2021	41,6 УТ, 45,9 ОНТ
4.2 Аймгийн Эрүүл мэндийн салбарын нийт зардалд өрх сумын эрүүл мэндийн төвийн буюу анхан шатны тусламж үйлчилгээний зардлын эзлэх хувийг нэмэгдүүлэх							
4.2.1	Нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгааны хүртээмжийг нэмэгдүүлэх	Иргэдийн эрүүл зан үйл төлөвшиж өвчлөл, нас баралт буурна	Хамрагдсан хүний тоо	Эрүүл мэндийн газар	АЗДТГазар	2017-2021	10,0-ОНТ
5.	Эрүүл мэндийн технологийн чиглэлээр						
5.1 Эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, оношлох, эмчлэх, нөхөн сэргээх болон эрүүл мэндийн мэдээллийн өртөг зардал хямд, хүртээмжтэй технологийг нэвтрүүлэх замаар хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах							
5.1.1	Хөдөөгийн эрүүл мэндийн	Малчны хотонд оношилно.		ЭМБ-ууд	АЗДТГазар, СЗДТГ	2017-2021	ОНТ

	байгууллагуудыг оношилгооны хөдөлгөөнт технологиор хангана.		Хангагдсан байгууллагын тоо				
6.	Эм зүйн тусламж үйлчилгээний чиглэлээр						
6.1 Сумдын эмийн эргэлтийн сангийн бүтэц зохион байгуулалтыг шийдвэрлэн, тусгай зөвшөөрөлтэй болгон иргэдэд чанартай үйлчилгээг хүргэх							
6.1.1	Сумдын ЭЭС-ийн тайлан,эд хөрөнгийн тооллогыг хийх	Санхүүгийн хяналт сайжирна	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Эрүүл мэндийн газар	ОНӨАлба	2017-2021	0
6.1.2	ЭЭС-уудыг тусгай зөвшөөрөлтэй болгох	Тусгай зөвшөөрөлтэй болно.	19 ЭЭСан тусгай зөвшөөрөлтэй болно.	Эрүүл мэндийн газар	ОНӨАлба	2017-2021	0
7.	Мэдээллийн технологи, мэдээллийн удирдлагын чиглэлээр						
7.1 Эрүүл мэндийн байгууллагуудтай цахимаар хурал хийж, мэдээ, мэдээллийг шуурхай солилцох боломжийг ханган ажиллах							
7.1.1	Сумдын аудио хурлын тоног төхөөрөмжөөр хангах	Шуурхай удирдлагаар хангагдана.	19 нэгж байгууллага	Эрүүл мэндийн газар	ЭМБ-ууд	2017	УТ
7.2 Телемедицин, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологийг ашиглан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах үйл ажиллагааг өргөжүүлэх							
7.2.1	Эмнэлгүүдийг камержуулах	Ил тод байдлыг хангагдана	20 нэгж байгууллага	Эрүүл мэндийн газар	ЭМБ-ууд	2018	9,0-ОНТ
7.2.2	Нэгдсэн эмнэлгийг цахим эмнэлэг болгох	Тусламж үйлчилгээний чанар сайжирна.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Эрүүл мэндийн газар	ЭМБ-ууд	2017-2021	20,0-УТ
8.	Эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалт, ил тод байдлын чиглэлээр						
8.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний ил тод байдлыг хангах, шийдвэр гаргахад иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлж, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх							
8.1.1	Эрүүл мэндийн салбарын ил тод	Тусламж үйлчилгээний чанар сайжирна.	Төлөвлөгөөний хэрэгжилт 90-ээс	Эрүүл мэндийн газар	Харьяа ЭМБ- ууд	2017-2021	0